

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2023/214/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өвөрхангай аймаг, Арвайхээр сум 2023 он	Тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com Ахлах аудитор: П.Хорлоосүрэн Утас: 70323108 Цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн хариуцагчийн өрхсөн ТТ Гэндэнгийн гудамж,
Дугаар тос: Арвайхээр сум, Өвөрхангай аймаг 52173,
Утас: Факс: (076) 7032 3253,
Цахим хуудан: ovorkhang.audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

Хувьд 01.06 № 01

Тайлан № _____

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН
СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.ДОЛГОРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.9 болон 8 дугаар зүйлийн 8.2 дахь зүйлүүдэд зааснаар тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцасны талаарх хязгаарлалтад хамрагдаагүй. Тус байгууллага нь 2022 онд 645,596,800 төгрөгийн санхүүжилт авч, 20,226,114 төгрөг төвлөрүүлсэн байна. Нийт 645,596,800 төгрөгийн санхүүжилтээс цалин хөлс болон нэмэлт урамшуулалд 486,954,565 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 61,022,648 төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 16,521,165 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 38,576,460 төгрөг, номативт зардалд 489,500 төгрөг багаж, техник, хэрэгсэл, урсгал засварт 10,494,890 төгрөг, дотоод албан томилолтын зардалд 6,702,700 төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 3,608,756 төгрөг тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

01593 0007

Төсвийн хөрөнгөөр 1,264,000 төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан мөн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 84,296,622 төгрөг, ШЕЗ-н ажлын албанаас 639,409.72 төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан байна. Ахмадын сан гэсэн данс нээж 1,000,000 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О. БАТЖАРГАЛ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/	
	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	26.4	34.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	594.3	625.6
Нийт хөрөнгийн дүн	620.6	659.8
Нийт өр төлбөрийн дүн	0.1	00
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	620.5	659.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	620.6	659.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	590.5	733.1
Үйл ажиллагааны зардлын дүн	556.4	693.9
Үйл ажиллагааны үр дүн	34.1	39.2
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	34.1	39.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	586.4	620.5
Тайлант оны үр дүн	34.1	39.2
Эцсийн үлдэгдэл	620.5	659.8
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	516.6	646.6
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	507.9	644.3
Үйл ажиллагааны ЦМГ		1.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ		1.0
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	512.3	625.4
Урсгал зардал	512.3	625.4
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	512.3	625.4
Улсын төсвөөс санхүүжих	512.3	625.4
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүхийн Тамгын газар нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэгтэй.

2022 онд ШЕЗ-ийн даргын албан даалгаврыг ханган биелүүлэх, шүүн таслах ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх, шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй болгох, шударга ёсыг бэхжүүлэх, шүүгч, ажилтнуудынхаа ажиллах орчин нөхцөлийг сайжруулах тэргүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улсын төсвийн санхүүжилтээр 74.8 сая төгрөгөөр нэгдсэн халаалтын шугманд холбосон байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэсэн.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар нь 2022 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг FAS системийн шилэн дансны мэдээллийн дагуу шалган тулгасан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 100 хувь байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас бусад зардалд төвийн хөрөнгө зарцуулсан эсэхийг тулган шалгах.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3.9 сая төгрөгийн зөрчил илэрч 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар Хөвсгөл аймагт Шүүх байгуулагдсаны 90 жилийн үйн нэрэмжит тэмцээнд оролцоход томилолтын зардал олгосон, шатахууны зардлаас талон болгож бараа материалын үлдэгдэлээр тайлагнасан зэрэг зөрчлүүд илэрч 2 зөвлөмж өгсөн.

Зөвлөмж-1 Байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас бусад ажиллаар явсан томилолтын зардлыг тухайн байгууллагын төсвөөс зарцуулахгүй, төсвийг хэмнэлттэй зарцуулж байх.

Зөвлөмж-2 Төсвийн жил дуусахад тухайн төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болж төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлж байх.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	3.9							2	3.9
	НИЙТ										

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

